



Thomas Jefferson Middle School

IB MYP-ийн 12-р сарын мэдээллийн хуудас

Өөрсдийгөө, ирээдүйгээ, дэлхий ертөнцөө ойлгож сайжруулахын төлөө хамтдаа суралцаж байна.



Энэ сарын шилдэг сурагч: МЭДЛЭГТЭЙ


Бүх сурах үйл явцын хүрээнд мэдлэг эзэмшдэг. Бид олон хичээлд хамааралтай гол ухагдахуунуудыг судалж мэддэг. Бид орон нутагт болон олон улсад ач холбогдолтой асуудлуудыг сонирхож судалдаг.



Манай шилдэг мэдлэгтэй сурагчид бол **Dolphins - Lizi Papinashvili, Dragons - Matthew Abramson, Eagles - Mariam McClure-Simonyan, Gators - Ryan Cohen, Monarch - Kennedy Carter, Owl - Alaina Setzo, Penguins - Kimber Shaw, Phoenix - Yassir Erami, Stingrays - Charles Scott.** Эх сурвалж: pixbay.com

Өөрийгөө дүгнэх, сургуулийг сайжруулах

Бид Jefferson сургуулийн IB MYP хөтөлбөрийн үнэлгээг угтан өөрийгөө дүгнэж байна. Бидэнд дуулгах сайн мэдээ байна: Манай сурагчид өөрсдийгөө IB MYP хөтөлбөрийн янз бүрийн даалгаварт "Онц" буюу "Онцсайн" гэж дүгнэсэн. Тодруулбал, судалгаанд хамрагдсан 525 оюутны 80.5 хувь нь зааж суралцах үйл ажиллагаа тэднийг сэтгэдэг, сонирхдог болгодог гэдэгтэй санал нэгджээ (баруун талын зураг: Цэнхэр = "Онц", Улаан = "Онцсайн", Улбар шар = "Сайжирч буй, Ногоон = "Эзэмшиж эхэлж буй"). Багш, эцэг эхчүүд судалгаанд удахгүй хамрагдана.



Үнэлгээний сургалт



Үнэлгээний үйл явцаа тогтвортой, ил тод, шударга байлгахын тулд бид шалгуур үзүүлэлтэд суурилсан үнэлгээ хийхээр болж байна. Үүнийг хийхийн тулд багш ажилтанд зориулсан сургалт, эцэг эхчүүдэд зориулсан мэдээллийн өдөрлөг зохион байгуулах хэрэгтэй юм. Одоогийн байдлаар 5 багш Норфолк хотод MYP хөтөлбөрийн үнэлгээний сургалтад хамрагдаж, нэг нь Ванкувер хотод үнэлгээний сургалтад суусан. 5 удирдах ажилтан, багш Өмнөд Каролина мужид сургалтад хамрагдахаар бүртгүүлсэн бөгөөд Мэрилэнд мужид дахин хоёр сургалтыг 1-р сард хийнэ. Бид 1-р сарын 21-ний 18 цагт номын санд эцэг эхчүүдэд зориулсан үнэлгээний семинар зохион байгуулна. Бид хоёр дахь семестрт бүх багш нарт стандартад суурилсан үнэлгээний ном өгөхийг зорьж байна. Эх сурвалж:

twitter.com/MrsBennettELA/status/1204928346506891265?s=20

MYP хөтөлбөрийн анги, бодит үнэлгээ

Манай Хэл, уран зохиолын хичээлийн 8-р ангийн багш нар шилжилт хөдөлгөөний талаарх бүлгээ саяхан зааж дуусгалаа. Манай 8-р ангийн сурагчид шилжилт хөдөлгөөний тухай итгэл үнэмшилтэй, сэтгэл догдлом өгүүлэл бичсэн. Сурагчид шүлэг, зурагт роман бичих эсвэл гэрэл зургийн дэлгэрэнгүй тайлбар бичих болон ангидаа уншиж, судалсан уран зохиолын талаар шүүмж бичих даалгавраас сонгосон юм. Дээрх зураг дээр нэг сурагч нэгэн залуу гэр бүл АНУ уруу нүүсэн зүрх шимшрэм нөхцөл байдлыг харуулахаар шийджээ. Энэ даалгаврыг А Шалгуур ашиглан үнэлсэн: Задлан шинжлэх С Шалгуур: Текст бичих. Хатагтай Madhi-н ангийн зураг.



Олон нийтийн төсөл

Бид YJР-н олон нийтийн төслийн хоёр дахь ээлжийг дуусгаж байна. Одоогоор хамгийн түгээмэл сэдэв бол амьтдад туслах явдал байв. Манай сурагчид нарийн боов борлуулж амьтдыг орон байраар хангахад тусалдаг. Гэвч Арлингтон хотод амьтдад туслах нь манай сурагчдын хийж бүтээхээр эрмэлзсэн цорын ганц зүйл биш юм. Сурагчид орангутанаас эхлээд улаан хулсны баавгай гээд дэлхийн өнцөг булан бүрд устаж ховордсон төрөл зүйлд анхаарч байна. Манай хүүхдүүд эдгээр амьтдад тулгарч буй аюул заналын талаарх мэдлэгээ дээшлүүлж байна. Мөн олон сурагчдын нэгдэл орон байргүй хүмүүст туслах, дэлхийн дулаарлыг бууруулах чиглэлд дахин анхаарлаа хандуулж байна. Өөр хэсэг бүлэг сурагчид давтлага өгөхөд анхаарч байгаа бөгөөд бөгөөд манай зарим сурагчид аль хэдийн Fleet Elementary сургууль дээр ажиллаж байна.

Өвлийн цугларалт

Манай хөгжмийн Урлагийн сурагчид баярын сэдэвт цуврал тоглолт хийлээ. 12-р сарын 11-нд бүх сурагчдад манай хоор дуу, найрал хөгжмийн болон үлээвэр хөгжмийн хамтлагийн тоглолтыг толилуулахаар концертын хуваарийг өөрчилсөн. 12-р сарын 17-нд бид 19.00 цагт хоор дууны концерт зохион байгуулж, сурагчид авьяас чадвараа олон нийтэд үзүүлэв. Эх сурвалж:



twitter.com/MrsBennettELA/status/1204928346506891265?s=20

Үйлчилгээнд суралцах

NJHS сургууль жил бүр зохион байгуулдаг лаазалсан хүнсний бүтээгдэхүүн хандивлах аяныг 11-р сарын 22-оос 12-р сарын 14-ний хооронд өрнүүлээ. Бүх ангийн сурагчид өөрсдийн цуглуулсан лаазалсан бүтээгдэхүүнийг туслах багшдаа өгчээ. Хоол хүнсний хандивыг "Doorways for Women" байгууллага (Гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх байр), Arlington Food Assistance Center төв (эмзэг бүлгийн өрхөд зориулсан хүнс) хувааж тараана. Хатагтай Kramer-н ахалсан арван сурагч бүх хандивын бүтээгдэхүүнийг цуглуулахад тусалсан.



Удахгүй болох арга хэмжээ, үйлчилгээний хуваарь

- Мягмар гараг бүр 17:00 цагт унадаг дугуй засах сайн дурын ажил Phoenix Bikes дэлгүүр дээр, 909 S. Dinwiddie St ([дэлгэрэнгүйг эндээс](#))
- Лхагва гараг бүр 18:30 цагт тахианы мах уутлах сайн дурын ажил AFAC дээр, 2708 S. Nelson St, ([дэлгэрэнгүйг эндээс](#))
- Пүрэв гараг бүр хичээлийн дараа 264 тоот танхимд Ноён Malinosky-тай хамт Jefferson сургуулийн байгаль орчны клуб дээр очоорой